



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2007 оны 1 сарын 17 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Дүрэм батлах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, Засгийн газрын 2006 оны 196 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны "Хот, нийтийн аж ахуйн хэлтэс"-ийн дүрмийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэхүү дүрмийг мөрдлөг болгон, хэлтсийн дотоод журмыг шинэчлэн боловсруулахыг Захирагчийн ажлын албаны Хот, нийтийн аж ахуйн хэлтэс /А.Энхбаяр/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2005 оны 71 тоот захирамжийн "Хот тохижилтын хэлтэс"-ийн дүрмийг баталсан хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц. БАТБАЯР

Нийслэлийн засаг даргын 2006 оны  
7 дугаар сарын 17 ны өдрийн 4-дүгээр  
захирамжийн хавсралт

## **УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ХОТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хот, нийтийн аж ахуйн хэлтэс /цаашид хэлтэс гэх/ нь хотын тохижилт, цэцэрлэгжилт, цэвэрлэгээний ажилд хяналт тавих, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, реклам, чимэглэл, ариутгах татуурга болон нийтийн үйлчилгээний тоног төхөөрөмж, архитектурын жижиг байгууламж, хөшөө дурсгал, нийтийн бие засах газар гэх мэт, хот, нийтийн аж ахуйн байгууламжийг барьж байгуулах, хот тохижилтын бодлого боловсруулах, тохижилтын байгууллагуудын ажлыг удирдан зохицуулах үүрэг бүхий нийслэлийн төрийн захиргааны байгууллагын нэгж мөн.

1.1. Хэлтэс нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж, Захирагчийн ажлын албанаас гаргасан дүрэм, журам, тушаал, шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.2. Хэлтсийн эрхлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын тохижилт, цэвэрлэгээ, ногоон байгууламж, гэрэлтүүлэг чимэглэл, хөшөө дурсгал, хаягжилт, реклам, мэдээллийн болон архитектурын жижиг байгууламж, нийтийн эзэмшлийн эд аж ахуйн арчилгаа, үйлчилгээ, түүнийг барьж байгуулах, үерийн далан суваг, борооны ус зайлуулах ил далд шугамын цэвэрлэгээ, түүнийг сэргээн засварлах ажил хамаарна.

1.3. Хэлтэс нь Захирагчийн ажлын албаны албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

### **Хоёр. Хэлтсийн удирдлага, зохион байгуулалт**

2.1. Хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг Хотын ерөнхий менежер томилж, чөлөөлнө. Хэлтэс нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж, нийслэлийн Засаг дарга, Тамгын газарт ажлаа хариуцан тайлагнана.

2.2. Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд Ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

2.3. Хэлтсийн даргыг ээлжийн амралт, удаан хугацааны сургалтанд хамрагдсан, томилолт, чөлөөтэй байх үед Ерөнхий менежерийн шийдвэрийн дагуу түүнийг хэлтсийн ахлах мэргэжилтэн орлоно.

2.4. Хот, нийтийн аж ахуй, хотын тохижилт, үйлчилгээний талаар төрөлжсөн судалгаа, мэдээллийн сантай байж, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой

мэдээллээр олон нийттэй тогтмол харилцаж ,мэдээллээ байнга шинэчилж ажиллана.

2.5. Хариуцах ажлын хүрээнд холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган, ажлын үр дүн, гүйцэтгэлийг ерөнхийд нь хянаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

### **Гурав. Хэлтсийн үүрэг**

3.1. Хэлтэс нь хот, нийтийн аж ахуй хот тохижилтын асуудлаар баримтлах бодлого, гарах хууль тогтоомж, хэтийн болон ойрын зорилтын дагуу нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тодорхой асуудал оруулах, батлагдсан төлөвлөгөө, даалгавар, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

3.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан нийслэлчүүдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, хот, нийтийн аж ахуй, хот тохижилтын асуудлуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тооцоо судалгаа хийж, тулгамдаж буй зорилтыг хэрэгжүүлэхэд санаачлага гарган ажиллана.

3.3. Хотын тохижилтын ажлыг дүүргийн нутаг дэвсгэрээр зохион байгуулж цэцэрлэгжилт, гэрэлтүүлэг, тохижилт, архитектурын жижиг байгууламж болон хөшөө дурсгал, далан суваг, ариутгах татуурган байгууламжуудыг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажил үйлчилгээ явуулахад гүйцэтгэлийн хяналт тавьж тайлагнана.

3.4. Хэлтэс нь нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, реклам чимэглэлийг тодорхой эзэнтэй болгох, хамгаалах, сайжруулах, арчилж тордох ажлыг дүүрэг, холбогдох байгууллагуудад хариуцуулж ажиллана.

3.5. Дүүргийн болон тохижилт, үйлчилгээний байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, тохижилтын байгууллагын ажиллагсадын ажлын нөхцөл байдал, ахуйн хангамж, хөдөлмөр хамгааллын асуудалд холбогдох байгууллагын санал санаачлагыг дэмжин хамтарч ажиллана.

3.6. Хэлтэс нь хотын тохижилт, нийтийн аж ахуйн талаар иргэд, мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авч, тэдний санал хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэгч байгууллагуудаар дамжуулан шийдвэрлэнэ.

3.7. Хэлтэс нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тохижилтын асуудлаар тусгагдсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэхэд хяналт тавина.

3.8. Нийтийн аж ахуй, хот тохижилтын ажилд туслах болон санаачлага гарган ажиллах байгууллага, иргэдийг дэмжиж, тэдний ажиллах бололцоогоор хангах, гэрээ байгуулах, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавих зэргээр хамтран ажиллана.

3.9. Хэлтэс нь хот, нийтийн аж ахуйг хөгжүүлэх, цаашдын зорилт, чиг хандлага, бодлогын болон хотын тохижилтын ажлын талаар сурталчилгаа явуулж, сургалт зохион байгуулна.

3.10. Хэлтэс нь жил, улирлын ажлын төлөвлөгөөтэй ажиллаж, хэлтсийн шуурхай зөвлөгөөнийг 14 хоног тутам хийнэ.

3.11 Төрийн албан хаагч бүрийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, улирлын төлөвлөгөөтэй ажиллуулж, улирлаар тайланг бичүүлэн, мэргэшлийн ур чадвар, үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр үнэлэн ярилцлага зохиож, зохих журмын дагуу ажлыг нь үнэлж дүгнэн шагнаж урамшуулна.

3.12 Хэлтэс нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажлын байрны тав тух, соёлыг дээшлүүлэх, ар гэр, ахуй амьдралд нь туслалцаа үзүүлэх, хамт олныг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг санаачлан зохион байгуулах болон захиргаанд санал боловсруулан тавьж ажиллана.

### **Дөрөв. Хэлтсийн эрх**

4.1. Хэлтэс нь хот, нийтийн аж ахуйн болон хот тохижилтын талаар тодорхой асуудлуудыг боловсруулж, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга бусад холбогдох байгууллагуудад оруулж шийдвэрлүүлнэ.

4.2. Хэлтэс нь хот, нийтийн аж ахуй, хотын тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд дэвшүүлж буй зорилт, хийж буй ажлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллана.

4.3. Хэлтэс нь хот, нийтийн аж ахуй, хотын тохижилт, цэвэрлэгээний ажлын мэдээ, судалгааг гарган нэгтгэж дүгнэхэд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж болно.

4.4. Хэлтэс нь эрхлэх асуудлын хүрээнд семинар, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах ба гадаад дотоодын адил төрлийн үйл ажиллагаанд хамрагдах, ном товхимол гаргах, гарын авлага материалаар хангах, сургалт сурталчилгаа явуулах, иргэдийн ахуйн соёл, хотжилт экологийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн ажлыг төлөвлөн жил жилд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.5. Хэлтэс нь албан хаагчийг дэвшүүлэх, сургалтанд хамруулах, арга хэмжээ авах, ажлаас өөрчлөх асуудлыг шийдвэрлүүлэхэд санал өгч тодорхойлж, уламжилж ажиллана.

4.6. Хэлтэс нь нийслэлийн нутаг дэвсгэрт хот, нийтийн аж ахуй, хотын тохижилт, өнгө үзэмжийн асуудлаар зөрчил дутагдал гаргасан байгууллага, иргэдийг хуулийн хүрээнд арга хэмжээ авахуулах, цаашид үйл ажиллагаа хэрхэн явуулах талаар санал боловсруулж, удирдах байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.7. Хот, нийтийн аж ахуйн хэлтсийн хариуцах ажлын хүрээнд ард иргэдээс тавьсан хүсэлт болон Нийслэл хотоо хөгжүүлэх талаар тавьсан санал, санаачлага, хөрөнгө оруулалт, зээл тусламж, хамтын ажиллагааны бүх хэлбэрийг дэмжин нийслэл хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт хөгжил цэцэглэлтийн төлөө бүх ажилтан, мэргэжилтнүүдийнхээ хүчийг дайчилж, хийсэн бүтээснээрээ үйл ажиллагааныхаа гол үр дүн болгож ажиллана.